



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 21 өдөр

Дугаар А/667

Мөрөн сум

Газрын зориулалт өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын санал, иргэн Д.Ганбаатарын ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн сумын Засаг даргын 2011 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/29 дүгээр захирамжийн хавсралтын 2 дахь заалтаар иргэн Цагаан овгийн Даваачулууны Ганбаатар (РК75042811) "Гэр бүлийн хэрэгцээний зориулалттай"-гаар эзэмшүүлсэн Мөрөн сумын 7 дугаар 29-15 тоотод байршилтай 6712008665 нэгж талбарын дугаартай 645м² газрын зориулалтыг өөрчилж, "Үйлчилгээтэй орон сууцны зориулалт"-тай болгон үлдсэн 25 жилийн хугацаатайгаар үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигч иргэн Цагаан овгийн Даваачулууны Ганбаатар (РК75042811)-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

